

**АУДИТЫН ТАЙЛАНГ
БЭЛТГЭСЭН:**

Булган аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Д.Анхбаяр

Аудитын менежер
Ж.Энхцоодол

Аудитор
Д.Даариймаа

2018 оны 06 дугаар
сар

Уг тайланг аймгийн
Төрийн аудитын
газраас авч үзнэ үү:

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70342495 утасаар
факс:70342496
дугаараар харилцана
уу

ХАЯГ:

Булган сум 5-р баг
Нутгийн удирдлагын
ордон
Өрөө № 403 тоот
Bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар 2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт 3-4

Бүлэг 1. Төсвийн орлогын төлөвлөлт түүний үр дүн:

1.1 Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн үү? 4-7

1.2 Тодотгол хийсэн үндэслэл шалтгаан бодитой эсэх? 7-11

Бүлэг 2: ЗДТГ-ын төсвийн төлөвлөлт, зарцуулалт:

2.1 ЗДТГ-ын төсвийн зардлыг хууль журмын дагуу зарцуулж байгаа эсэх? 11-19

2.2 ЗД-ын нөөц хөрөнгийн зарцуулалт хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх? 19-21

2.3 ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн? 21-23

Дүгнэлт, зөвлөмж 23-24

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НА	Нийцлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААН	Аж ахуйн нэгж
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын нэр

“16 сум болон 1 тосгоны ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл”.

2. Аудитын код

БУА-2018-01-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

4. Аудитын зорилт:

Сумдын ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж үнэлэлт өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршино.

5. Аудитын хамрах хүрээ

Сумдын орон нутгийн орлогын төлөвлөгөө, бүрдүүлэлт, хувиарлалт, зарцуулалт, ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагааг хамрууллаа.

6. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэллээ.

7. Аудитын арга зүй:

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллагын ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

8. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль

- Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 11 сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Холбогдох бусад хууль, тогтоомж

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

Нэг. Төсвийн орлогын төлөвлөлт түүний үр
дүн?

Бүлэг I

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний нэмэлт өөрчлөлтөөр хадгаламжийн хүүгийн орлогоос албан татвар ногдуулахыг тодорхойлж өгсөн боловч хуулийн дагуу тодотголоор нэмж тусгаагүй байна.

1.1. 16 сум, 1 тосгоний орон нутгийн нийт орлогыг 98209.1 мянган төгрөгөөр буюу 5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Сумдын татварын орлого 2017 онд 105 хувиар буюу 98209.1 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Үүнээс 12 сум, 1 тосгон орон нутгийн орлогыг давуулан биелүүлсэн байна.

Орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сумдын нэр	Тодотгол	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Баян-Агт	80660.8	95689.7	15028.9	119%
2	Баяннуур	45342.0	47699.7	2357.7	105%
3	Бугат	79676.9	87978.0	8301.1	110%
4	Булган	506240.6	498787.2	-7453.4	99%
5	Бүрэгхангай	75606.6	82536.2	6929.6	109%
6	Гурванбулаг	61658.7	75776.8	14118.1	123%
7	Дашинчилэн	76048.5	89203.1	13154.6	117%
8	Могод	54417.2	64018.7	9601.5	118%
9	Орхон	99166.1	103968.3	4802.2	105%
10	Рашаант	64289.7	81221.8	16932.1	126%
11	Сайхан	56305.4	73504.2	17198.8	131%
12	Сэлэнгэ	266327.8	261192.3	-5135.5	98%
13	Тэшиг	114647.7	99128.0	-15519.7	86%
14	Хангал	100817.6	112576.3	11758.7	112%
15	Хялганат	36817.1	43255.5	6438.4	117%
16	Хишиг-Өндөр	62426.0	69508.5	7082.5	111%
17	Хутаг-Өндөр	157548.2	150161.7	-7386.5	95%
	Нийт	1937996.9	2036206.0	98209.1	

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг Тэшиг сум 15519.6 мянган төгрөгөөр буюу 14 хувиар, Булган сум 7453.4 мянган төгрөгөөр буюу 1 хувиар, Хутаг-Өндөр сум 7386.5

буюу 5 хувиар, Сэлэнгэ сум 5135.5 мянган төгрөгөөр буюу 2 хувиар тус тус тасалсан байна.

Тэшиг сум 114647.7 мянган төгрөгөөр орон нутгийн орлогыг төлөвлөж 99128.0 мянган төгрөгийн орлого оруулснаас хувь хүний орлогын албан татвар 2852.6, үйл ажиллагааны орлого 8546.5, галт зэвсгийн албан татвар 1882.0, улсын тэмдэгтийн хураамж 3308.4, хог хаягдлын үйлчилгээний хураамж 6536.8, ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны төлбөр 834.2, ойн нөөц ашигласны төлбөр 8734.3, торгуулийн орлогыг 4355.9 мянган төгрөгөөр тасалсан байна. Төлөвлөсөн орлогууд тасарсан шалтгаан нь үйл ажиллагааны орлого нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэний орлого буурсан, галт зэвсгийн албан татвар нь татвар нэмэгдсэнтэй холбоотой буугаа шилжүүлэх болон хасалт их хийлгэсэн, хог хаягдлын хураамж байгаль хамгаалагч, татварын байцаагч нар хураах эрхгүй, хураамж авах байцаагч байхгүй учраас тасарсан, ойн нөөц ашигласны орлого нь тусгай хамгаалалттай газраас бэлтгэх цэвэрлэгээний ажлыг зөвшөөрөл авсан ААН бэлтгээгүй, ажил хийгээгүй, хүү торгуулийн орлого байгаль орчны хяналтын байцаагч ажлаасаа гарсантай холбогдон орлого тасарсан байна.

Булган сум нь орон нутгийн орлогын төлөвлөгөөг 506240.6 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 498787.2 мянган төгрөг оруулснаас галт зэвсгийн албан татварыг 9.0, улсын тэмдэгтийн хураамж 25160.9, хог хаягдлын үйлчилгээний хураамж 23454.2, ойн нөөц ашигласны төлбөр 191.5, ан амьтны нөөц ашигласны төлбөр 413.0 мянган төгрөгөөр тасарч ус рашаан ашигласны төлбөр, нохойн татварыг тус тус 1000.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр орлого оруулаагүй байна. Төлөвлөсөн орлогууд тасарсан шалтгаан нь улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тооцоо судалгаатай төлөвлөөгүйгээс, хог хаягдлын хураамж 23454.2 мянган төгрөг тасарсан нь 9,0 сая нь буруу төлөвлөснөөс үлдэгдэл 14454.2 мянган төгрөг нь хогны хураамжийг төвлөрүүлэх талаар аймгийн Татварын хэлтэс, Төрийн банк, Хот тохижилт үйлчилгээний ангийн гурвалсан гэрээгээр иргэд өөрсдөө тушаадаг байсан нь иргэдийн идэвхи санаачлага муутайгаас шалтгаалсан.

Хутаг-Өндөр сум нийт орлогыг 157548.2 мянган төгрөгөөр төлөвлөж, 150161.7 мянган төгрөг оруулснаас үйл ажиллагааны орлого 23384.8, галт зэвсгийн албан татвар 1000.0, улсын тэмдэгтийн хураамж 1992.5, хог хаягдлын үйлчилгээний хураамж 6450.2, торгуулийн орлогыг 5841.9 мянган төгрөгөөр тус тус тасалсан нь үйл ажиллагааны орлого, суутгагч хувь хүний орлого хоорондоо гүйсэн, галт зэвсгийн татварыг дутуу хураасан, хүү торгуулийн бэлэн бус торгуулийн машинаар тавигдсан торгууль төлөгдөөгүйтэй холбоотой байна.

Сэлэнгэ сум 266327.8 мянган төгрөгөөр орон нутгийн орлогыг төлөвлөж 261192.2 мянган төгрөг оруулснаас үйл ажиллагааны орлого 7931.0, улсын тэмдэгтийн хураамж 3393.4, хог хаягдалын үйлчилгээний хураамж 3303.4, ойн нөөц ашигласны төлбөр 18191.2, ус рашааны нөөц ашигласны төлбөр 34.5, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1840.0 мянган төгрөгөөр тасарч торгуулийн орлогыг 5800.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч орлого төвлөрүүлээгүй байна. Төлөвлөсөн орлогууд тасарсан шалтгаан нь үйл ажиллагааны орлого аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу орон нутгийн иргэдээс худалдан авсан татварын орлого хувь хүний орлогын албан

татварын гүйцэтгэлд гарсантай, тэмдэгтийн хураамжийн орлого төлөвлөлтийн алдаатай, ойгоос мод бэлтгэсний орлого “Зэд хантай бүтээлийн нурууны тусгай хамгаалалтын захиргаа” цэвэрлэгээний огтлол болон цэвэрлэгээний ажлаар 16800.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн ч ажил хийгдээгүй, иргэд, нөхөрлөлийн мод цэвэрлэгээний ажил хийгдээгүйтэй, хог хаягдлын орлого төлөвлөсөн орлогыг бүрэн оруулаагүйтэй, ангийн орлого, усны төлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлого зэрэг нь төлөвлөлтэй холбоотой тасарсан байна.

Сумдын орлого төлөвлөлтөөс галт зэвсгийн татварын дутуу 350.0, ХХОАТ-ыг сумын орлогын дандсан төвлөрүүлээгүй 134.0, усны орлогын дутуу 150.0, түрээсийн орлогын дутуу 1206.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, газрын төлбөрийн дутуу 18547.7 мянган төгрөгийн албан шаарлага тус тус бичлээ.

Дээрхи орлогын илүү, дутуу үзүүлэлтээс үзэхэд сумын орлогын төлөвлөгөөг дутуу, биелэгдэхгүй орлогыг төлөвлөхгүй, бодит тооцоон дээр болон сумынхаа онцлогт тулгуурлан төлөвлөн батлуулах, орон нутгийн татварын орлогыг биелүүлж Татварын тухай хуулийн 29.1.10 дахь “албан татвар, төлбөр, хураамж, алданги, торгуулийг хуульд заасан хугацаанд хурааж төсөвт оруулах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Цаашид орон нутгийн орлогыг тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл, өмнөх оны дутуу төлөлт зэргийг нэр төрлөөр тооцож төлөвлөлтөнд тусган гүйцэтгэлийг бүрэн ханган биелүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

Сумдад нийтлэг тасарсан орлогыг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Үзүүлэлт	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл тийн хувь
1	Үйл ажиллагааны орлого	214011.9	128484.2	-85527.7	60.0
2	Галт зэвсгийн албан татвар	65890.0	60407.3	-5482.7	91.7
3	Улсын тэмдэгтийн хураамж	189000.0	150012.0	-38988.0	79.4
4	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	145114.5	89671.3	-55443.2	61.8
5	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	32178.9	30640.2	-1538.7	95.2
6	Ойн нөөц ашигласны төлбөр	331716.4	310734.0	-20982.4	93.7
7	Нохойн татвар	3700.0	2499.5	-1200.5	67.6
8	Торгуулийн орлого	152450.0	139975.5	-12474.5	91.8
	Нийт	1134061.7	912424.0	-221637.7	

Сумдын орон нутгийн орлогыг татварын нэр төрлийн нийт гүйцэтгэлээс үзэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх үйл ажиллагааны орлого 85527.7, галт зэвсгийн албан татвар 5482.7, улсын тэмдэгтийн хураамж 38987.9, хог хаягдлын үйлчилгээний хураамж 55443.2, ойн нөөц ашигласны төлбөр 20982.4, ус рашаан ашигласны төлбөр 1538.7, нохойн татвар 1200.5, торгуулийн орлого 12474.5 мянган төгрөгөөр тасарсан нь Татварын тухай хуулийн 29.1.10 дахь “албан татвар, төлбөр, хураамж, алданги, торгуулийг хуульд заасан хугацаанд хурааж төсөвт оруулах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр орлогуудаас жил бүр тасардаг хогны орлогын гүйцэтгэлийг сумдаар харуулбал:

/мян.төг/					
№	Сумдын нэр	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Баян-Агт	4043.4	4188.9	145.5	104%
2	Баяннуур	3000	3011.4	11.4	100%
3	Бугат	2200	2674.8	474.8	122%
4	Булган	51367.1	27912.9	-23454.2	54%
5	Бүрэгхангай	7522	6001.6	-1520.4	80%
6	Гурванбулаг	10644.7	3684.5	-6960.2	35%
7	Дашинчилэн	3738	3738	0	100%
8	Могод	2823.9	2204	-619.9	78%
9	Орхон	7035.5	4936.8	-2098.7	70%
10	Рашаант	4987.6	6156.5	1168.9	123%
11	Сайхан	6577.2	3325	-3252.2	51%
12	Сэлэнгэ	6417.9	3114.5	-3303.4	49%
13	Тэшиг	8646.8	2110	-6536.8	24%
14	Хангал	5009.7	2962.5	-2047.2	59%
15	Хялганат	4681.6	4637	-44.7	99%
16	Хишиг-Өндөр	4585.1	3629.1	-956	79%
17	Хутаг-Өндөр	11834	5383.8	-6450.2	45%
	Нийт	145114.5	89671.3	-55443.2	

Хогны орлогын өмнөх жилүүдийн гүйцэтгэлээс үзэхэд хогны орлого жил бүр тасардаг шалтгаан нь хогны орлого төвлөрүүлэлтийг хариуцсан этгээд байхгүй, татварын байцаагч, байгаль хамгаалагч нар хариуцдаггүй, хог хаягдлын хураамжийн төлөлтөнд тавих хяналт сул байгаа нь Хог хаягдлын тухай хуулийн 9.4 дэх “Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 9.4.8 дэх “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих,” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж, орлого, татвар хариуцсан албан тушаалтнуудаар ажил хийлгэх шаардлагатай байна.

1.2. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний нэмэлт өөрчлөлтөөр хадгаламжийн хүүгийн орлогоос албан татвар ногдуулахыг тодорхойлж өгсөн боловч хуулийн дагуу тодотголоор нэмж тусгаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 12-ны 04/04 дугаар тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06/01 дугаар тогтоолоор 2017 оны төсвийг тодотгон батлагдсаныг үндэслэн сумын ИТХ орон нутгийн орлого, зарлагыг төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэхь заалтын дагуу тодотгол хийсэн байна.

Сумдын орон нутгийн орлогын 2017 оны батлагдсан төсөв, тодотгол:

/мян.төг/

№	Сумдын нэр	Батлагдсан төсөв	Эхний тодотгол	Сүүлийн Тодотгол	I тодотголын өөрчлөлт	II тодотголын өөрчлөлт
1	Баян-Агт	77727.8	80660.8	80660.8	2933.0	0.0
2	Баяннуур	69088.4	49242.0	45342.0	-19846.4	-3900.0
3	Бугат	81476.9	79676.9	79676.9	-1800.0	0.0
4	Булган	477370.2	505240.6	505240.6	27870.4	0.0
5	Бүрэгхангай	64152.3	75606.6	75606.6	11454.3	0.0
6	Гурванбулаг	65658.7	61658.7	61658.7	-4000.0	0.0
7	Дашинчилэн	86048.5	76048.5	76048.5	-10000.0	0.0
8	Могод	52417.2	54417.2	54417.2	2000.0	0.0
9	Орхон	114166.1	114166.1	99166.1	0.0	-15000.0
10	Рашаант	61789.7	66389.7	64289.7	4600.0	-2100.0
11	Сайхан	56305.4	56305.4	56305.4	0.0	0.0
12	Сэлэнгэ	214727.8	266627.8	266327.8	51900.0	-300.0
13	Тэшиг	132887.7	114647.7	114647.7	-18240.0	0.0
14	Хангал	79079.5	101445.8	100817.6	22366.3	-628.2
15	Хялганат	54301.5	36817.1	36817.1	-17484.4	0.0
16	Хишиг-Өндөр	62226	62226	62426	0.0	200.0
17	Хутаг-Өндөр	194421.7	157548.2	157548.2	-36873.5	0.0
	Нийт	1943845.4	1958725.1	1937996.9	14879.7	-20728.2

Сумдын 2 удаагийн тодотголоос үзэхэд эхний тодотголоор Баян-Агт 2933.0, Булган 27870.4, Бүрэгхангай 11454.3, Могод 2000.0, Рашаант 4600.0, Сэлэнгэ 51900, Хангал 22366.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, Баяннуур 19846.4, Бугат 1800.0, Гурванбулаг 4000.0, Дашинчилэн 10000.0, Тэшиг 18240.0, Хялганат 17484.4, Хутаг-өндөр 36873.5 мянган төгрөгөөр хассан байна.

Сүүлийн тодотголоор Баяннуур 3900.0, Орхон 15000.0, Рашаант 2100.0, Сэлэнгэ 300.0, Хангал 628.2 мянган төгрөгөөр хасаж, Бүрэгхангай сум 200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Бугат сумын оны сүүлийн тодотголоос үзэхэд орлогын гүйцэтгэлийн дагуу төсвийг тодотгон баталсан, 12 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээ сумын ИТХ-ын 2017 оны 12 сарын 20-ны өдрийн 04/02 дугаар тогтоолоор баталсан дүнтэй зөрүүтэй мэдээлсэн байна.

Сумдын орон нутгийн орлогын тодотголд хадгаламжийн хүүгийн орлогыг тооцож төлөвлөгөөнд тусгаагүй нь хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний нэмэлт өөрчлөлтөөр хадгаламжийн хүүгийн орлогоос албан татвар ногдуулахыг тодорхойлж өгсөн боловч хуулийн дагуу тодотголоор нэмж тусгаагүй зөрчил илэрлээ.

Орон нутгийн орлогын тодотголоос үзэхэд орлогын гүйцэтгэлийн дагуу төсвийг тодотгон баталдаг, орлого нэмэгдвэл тодотгол хийж нөөц хөрөнгөнд зарцуулдаг, орлогын төлөвлөгөө тасарвал хасаж тодотгодож баталсан байна.

Сумдын ЗДТГ-ын 2017 оны зардлын батлагдсан төсөв, тодотгол:

/мян.төг/

№	Сумдын нэр	Батлагдсан төсөв	Тодотгол I	Тодотгол II	I тодотголын өөрчлөлт	II тодотголын өөрчлөлт
1	Баян-Агт	188352.6	190902.6	204124.2	2550	15771.6
2	Баяннуур	219982.2	206288.3	221062.3	-13693.9	1080.1
3	Бугат	204464.9	236088.8	241675.5	31623.9	37210.6
4	Булган	381112.3	420320.8	433973.9	39208.5	52861.6
5	Бүрэгхангай	245298.5	237627.5	255715.4	-7671	10416.9
6	Гурванбулаг	226589.0	222276.7	228579.7	-4312.3	1990.7
7	Дашинчилэн	218091.4	230063.2	248677.0	11971.8	30585.6
8	Могод	193363.7	217413.7	233865.6	24050	40501.9
9	Орхон	224462.9	228407.9	266116.4	3945	41653.5
10	Рашаант	249706.6	267307.1	289157.9	17600.5	39451.3
11	Сайхан	179788.5	192859.6	241561.6	13071.1	61773.1
12	Сэлэнгэ	243353.5	245603.4	257806.8	2249.9	14453.3
13	Тэшиг	214535.2	229687.7	250047.9	15152.5	35512.7
14	Хангал	208997.6	229961.0	258330.1	20963.4	49332.5
15	Хялганат	149533.9	194311.9	194611.9	44778	45078.0
16	Хишиг-Өндөр	185722.3	197962.9	214278.1	12240.6	28555.8
17	Хутаг-Өндөр	210033.3	216948.2	255774.1	6914.9	45740.8
	Нийт	3743388.4	3964031.3	4295358.4	220642.9	551970.0

Сумын ЗДТГ-ын зардлын тодотголоос үзэхэд эхний тодотголоор зардлыг Баяннуур сумын ЗДТГ 13693.9, Бүрэгхангай 7671.0, Гурванбулаг сум 4312.3 мянган төгрөгөөр хасаж, бусад сум 2249.9-44778.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сүүлийн тодотголоос үзэхэд бүх сумд 1080.1-61773.0 мянган төгрөг нэмэгдүүлсэн байна.

Сумдын ЗДТГ-ын зардлыг тодотголоор ихээр нэмэгдүүлсэн сумдын шалтгааныг дурьдвал: Сайхан сумын Мал эмнэлэгийн үржлийн тасгийн дарга ажилд авснаас цалингийн зардал 14275.5, халаалтын зардлын өр барагдуулахад 28215.4, орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж 9311.7, төрийн албан хаагчдад олгох сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 5400.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Булган сумын ЗДТГ нь шинэ байранд орсноос шалтгаалан 2 үйлчлэгч, 1 цахилгаанчин нэмж авснаас цалингийн зардал 10320.0, тогтмол зардал 10886.9, бичиг хэргийн зардал 250.0, сумын Засаг дарга гадаад томилолтоор явснаас шалтгаалан 1860.0, шинэ байрны хурлын зааланд ширээ сандал авахад эд хогшилийн зардлыг 7686.9, бараа үйлчилгээний бусад зардлыг 140.0, төрийн албан хаагчдад олгох сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 11000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Хангал сумын ЗДТГ нь шатахуун өр үүссэн тул тээвэр шатахууны зардлыг 825.0, шуудан холбооны зардлыг 372.0, 4 галч, жолоочид нормын хувцас авж нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 425.0, урсгал засварын зардлыг 2870.0, томилолтын өр барагдуулахаар томилолын зардлыг 1543.5, сумдын засаг дарга нар япон улсруу явсан тул гадаад томилолтын зардлыг 3000.0, оношлогоо төлбөр нэмэгдсэнээс даатгалын үйлчилгээний зардал 137.5, хичээл үйлдвэрлэлийн зардал 250.0, суманд эмийн сангүй байсан тул эргэлтийн эмийн сангийн байшингийн асуудлыг шийдэж өгөхөд 5500.0, давсан орлогоороо сумын олон нийтийн ажилд хэрэглэх зорилгоор бага оврын старикс автомашин худалдан авахаар тоног төхөөрөмжийн зардлыг 21000.0, орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж 5011.6, төрийн албан хаагчдад олгох сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 6300.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Хутаг-Өндөр сумын ЗДТГ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4440.0, халаалтын өр барагдуулахад 20590.0, тээвэр шатахуун 700.0, багаж техник хэрэгслийн зардал 1400.0, албан томилолтын зардалд 1020.0, мэдээлэл сурталчилгааны зардал 250.0, урсгал засвар 1590.0, орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж 9250.8, төрийн албан хаагчдад олгох сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 6000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Могод сумын ЗДТГ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11 хувиар танаснаас хүрэлцэхгүй байсан тул цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 22200.0, томилолтын зардалд 900.0, урсгал засварын зардалд 507.0, тээвэр шатахууны зардалд 984.0, бусад зардалд 516.0, биеийн тамир спортын зардалд 250.0, төлбөр хураамжийн зардалд 200.0, орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж 8893.0, төрийн албан хаагчдад олгох сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 5100.0, нэг удаагийн тэтгэмжинд 959.0 мянган төгрөг тус тус нэмэгдүүлжээ.

Орхон сумын ЗДТГ нь халаалтын өр барагдуулахад 29997.3, автомашин засварлахаар урсгал засварын зардалд 2000.0, шуудан холбооны зардалд 194.2, бусдаар зардалд 40.1, орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж 5011.7, төрийн албан хаагчдад сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 5700.0, шүүхийн шийдвэрээр олгох тэтгэмжинд 1460.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Рашаант сумын ЗДТГ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хүрэлцэхгүйн улмаас 2870.0, бичиг хэргийн зардалд 400.0, цэцэг өвчин, шүлхий, ой хээрийн түймэр гарсан зэргээс шалтгаалан тээвэр шатахууны зардлыг 7900.0, урд оны томилолтын өр барагдуулахаар 4500.0, бараа үйлчилгээний бусад зардлыг 250.0, урсгал засварын зардалд 1000.0, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг 6553.5, орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж 9250.7, төрийн албан хаагчдад сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал 6600.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Сумдын ЗДТГ-ын тодотголын нэмэгдлээс үзэхэд халаалтын өр барагдуулахад, тайлант жилийн явцад зайлшгүй өөрчлөлтөөс шалтгаалтсан хүрэлцэхгүй зардалд орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж, төрийн

албан хаагчдад сахилга, хариуцлага ажлын үр дүнгийн урамшуулал зэрэг зардалаас шалтгаалан нэмэгдсэн байна.

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

**Хоёр. Байгууллагын санхүү, аж ахуйн үйл
ажиллагаа ил тод нээлттэй байна уу?**

Бүлэг II

Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа ЗГ-ын тогтоол, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.1. Сумдын ЗДТГ-ын төсвийн орлого, зардлыг хууль журмын дагуу зарцуулаагүй байна?

Сумдын тамгын газрууд 2017 онд орон нутгийн төсвөөс 4295358.4 мянган төгрөгөөр санхүүжихээр төлөвлөж 4295350.1 мянган төгрөгөөр санхүүжиж гүйцэтгэлээр 4231936.3 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 63413.8 мянган төгрөгийн Төвийн тухай хуулийн 7.7 заалтын дагуу төвлөрүүлсэн байна.

Сумдын ЗДТГ-ууд нь өөрийн орлогоор 55874.4 мянган төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 59999.3 мянган төгрөг оруулж давуулан биелүүлсэн 4124.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сумдын ЗДТГ-ын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сумдын нэр	ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө	ЗДТГ-ын өөрийн орлогын гүйцэтгэл	Орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү	Тодотгосон төлөвлөгөө	Санхүүжилт	Гүйцэтгэл	Зарцуулаагүй үлдэгдэл	Төвлөрүүлэх шилжүүлэг
1	Баян-Агт	3500.0	4417.0	917.0	204124.2	204124.2	204021.0	103.2	1020.2
2	Баяннуур	3126.8	3126.8	0.0	221062.3	221062.3	220740.7	321.6	321.6
3	Бугат	1800.0	1760.1	-39.9	241675.5	241675.5	241034.4	641.1	601.2
4	Булган	17886.0	18753.8	867.8	433973.9	433418.0	424642.2	8775.8	9643.6
5	Бүрэгхангай	710.0	710.0	0.0	255715.4	255715.4	250916.9	4798.5	4798.5
6	Гурванбулаг	2000.0	2640.0	640.0	228579.7	228579.7	227153.4	1426.3	2066.3
7	Дашинчилэн	10000.0	11583.9	1583.9	248677.0	244980.2	243450.0	1530.2	3114.1
8	Могод	1459.0	1459.0	0.0	233865.6	233865.6	231598.5	2267.1	2267.1
9	Орхон	1000.0	971.5	-28.5	266116.4	266116.4	266042.3	74.1	45.6
10	Рашаант	2500.0	2539.5	39.5	289157.9	289157.9	289157.9	0.0	39.5
11	Сайхан	1300.0	1061.6	-238.4	241561.6	241561.6	239526.7	2034.9	1796.5
12	Сэлэнгэ	300.0	386.0	86.0	257806.8	256985.0	242586.7	14398.3	14484.3
13	Тэшиг	240.0	260.0	20.0	250047.9	254749.6	239063.7	15685.9	15705.9
14	Хангал	628.2	628.2	0.0	258330.1	258330.1	253120.9	5209.2	5209.2
15	Хялганат	6284.4	6721.8	437.4	194611.9	194976.6	194292.9	683.7	1121.2
16	Хишиг-Өндөр	1140.0	980.0	-160.0	214278.1	214277.9	211161.2	3116.7	2956.7
17	Хутаг-Өндөр	2000.0	2000.0	0.0	255774.1	255774.1	253427.1	2347.0	2347.0
	Нийт	55874.4	59999.3	4124.9	4295358.4	4295350.1	4231936.3	63413.8	67538.7

Сумдын ЗДТГ төлөвлөгөөгөөр 4295358.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж гүйцэтгэлээр 4295350.1 мянган төгрөг авсан нь Булган сум 555.9, Дашинчилэн сум 3696.8, Сэлэнгэ сум 821.8 мянган төгрөг дутуу санхүүжиж, Хангал сум 4701.8, Хялганат сум 364.7 мянган төгрөгөөр илүү санхүүжисэн байна.

Санхүүжилтээс 63413.8 мянган төгрөгийг зарцуулаагүй байгаагаас үзэхэд сумдад төсвийг хэмнэлттэй зарцуулах боломж байгааг харуулж байна.

Сумдын ЗДТГ-ын 2017 оны төсвийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчлөөс дурьдвал:

Бугат сумын ЗДТГ төсвөөс даатгалын үйлчилгээний зардлаас 68.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, шуудан холбооны зардлаас 130.0 мянган төгрөгийн бичиг хэрэг материал худалдан авж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад зардлаас 55.0 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд зарцуулсан, аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардлаас 80.0 мянган төгрөгийг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 100.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрт зарцуулсан Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 5.1 дахь “Төсвийн байгууллага энэ журмын 3.1-т заасан үндэслэлээр дээд шатны төсвийн захирагчаас зөвшөөрөл авсны дагуу 4.1-т заасан агуулга бүхий зардлын бүлэг хооронд хийх зохицуулалтын саналаа харьяа төрийн санд хүргүүлнэ.” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Бугат сумын ЗДТГ нь өөрийн орлогыг 1800.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1760.1 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 97.7 хувь биелүүлжээ.

Сумын ЗДТГ нь ахуй үйлчилгээний байр, Шатахуун түгээх станцын түрээсийн гэрээний орлого, Хаан банкны халаалтын төлбөр нийт 4426.2 мянган төгрөг орохоор гэрээ байгуулсан боловч түрээслэгчдээс 3319.8 мянган төгрөгийн төлбөр орж 1106.4 мянган төгрөг дутуу оруулсанд төлбөрийн акт тогтоолоо. Түрээсийн орлогыг дутуу оруулсан дүнгээр байгууллагын данс бүртгэлд авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 26.1 дэх “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шатахуун түгээх станцын түрээсийн эхний 4 сарын 400.0 мянган төгрөгийн төлбөрийг бэлнээр авч худгийн урамшуулалд 300.0 мянган төгрөг зарцуулсан боловч 100.0 мянган төгрөгийн зарцуулалтын баримт дутуу зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Сумын ЗДТГ нь өөрийн орлогоор ахуй үйлчилгээний байр, Шатахуун түгээх станцын түрээсийн гэрээ, Хаан банкны халаалтын төлбөрийн гэрээний дагуу нийт 4724.8 мянган төгрөг олох боломжтой боловч өөрийн орлогын төлөвлөгөөг 1800.0 мянган төгрөгөөр баталсан нь өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн гүйцэт төлөвлөж ИТХ-аар батлуулаагүй байна. Гүйцэтгэлээр 3319.8 мянган төгрөгийн түрээсийн орлого орж 1755.1 мянган төгрөгийг ЗДТГ-ын үйл ажиллагаанд зарцуулахаар баталсны дагуу зарцуулж, ИТХ-аар батлуулалгүй нэмэлт санхүүжилтийн дансаар болон бэлнээр хураасан 1564.7 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн 991.0 мянган төгрөгийг худгийн урамшуулалд, 100.0 мянган төгрөгийг баримтгүйгээр зарцуулж 473.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн байна.

Иймд өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн төлөвлөж ИТХ-аар батлуулж, ИТХ-аар батлуулан зарцуулах шаардлагатай байна.

Бүрэгхангай сумын ЗДТГ-ын 2017 оны төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийгдсэн, жилийн эцэст бэлэн мөнгө гарган гүйлгээ хийсэн боловч бэлэн мөнгөний үлдэгдлийг санхүүгийн тайланд тайлагнаагүй, бараа материалын тайланг үлдэгдлээр гаргадаггүй, нэмэлт санхүүжилтийн дансны шатахууны 2240.2 мянган төгрөгийн зарцуулалтыг материалын тайланд тайлагнаагүй, шууд зардлаар тайлагнасан, нягтлан бодогч няравын тайланг

үндэслэн санхүүгийн тайланг тайлагнаагүй, нярав бараа материалын тайланг мөнгөн дүгнээр тайлагнадаггүй, нэмэлт дансны 124127.5 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримт байхгүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, Сангийн сайдын 69 тоот тушаалаар баталсан "Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм" зэргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.Тухайлбал:

Цалингийн урьдчилгаа болон олголтыг түүвэрлэн тулгахад 2 ажилтанд 41.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон, 1 ажилтны 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил илэрч цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй 400.0 мянган төгрөгт төлбөрийн акт бичлээ.

Мөн бараа материалын тайланд 2405.6 мянган төгрөгийн жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй зөрчил илэрснийг аудитын явцад барагдуулж даргын цохолтгүйгээр шатахуун зарцуулсан 1581.8, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн 1524.8 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага бичлээ.

Хангал сумын ЗДТГ нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг хэмнэсэн ч, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар шимтгэлийн зардалд 52.8 мянган төгрөгний өртэй, жолоочийн тооцоо бодоогүй хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүй, замын хуудсаар бензинийг тулган бичдэг, шатахууны анхан шатны баримтыг бүрдүүлж няравын тайланг иж бүрэн тайлагнаж нягтлан бодох бүртгэлд тусгах, шуудан холбоо утасны зардалд төсвөөс 5.0-15.0 мянган төгрөг 11 хүнд сар бүр 62.0 мянган төгрөг бэлнээр олгосон, албан хаагчдад Засаг даргын захирамж 2017 оны Б/25, Тамгын газрын даргын 2017 оны Б/27 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулал олгохдоо ажил дүгнэсэн шалгаруулалт байхгүй, төрийн үйлчилгээний болон гэрээт ажилчдад ур чадварын урамшууллыг ажлын үр дүнтэй нь уялдуулаагүй, байгаль хамгаалагчийн гоожингийн орлогын тооцоог хийгээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор сум дундын цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд зарцуулах 1000.0 мянган төгрөгийн болон томилот, шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрсэнг аудитын явцад барагдуулж ажиллаа.

Сэлэнгэ сумын ЗДТГ нь зардлыг нийт дүнгээр болон зүйл ангиар хэтрээгүй гэж тайлагнасан боловч нэр төрлөөр нь авч үзвэл түлш халаалтын зардлаас 6 удаагийн шилжүүлгээр шатахуунд 2513.7, 1 удаагийн шилжүүлгээр сэлбэгэнд 331.2, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас шатахуунд 1 удаагийн шилжүүлгээр 100.0, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 3 удаагийн шилжүүлгээр сэлбэгэнд 63.0, холбоонд 16.1, бичиг хэргийн материалд 27.5 нийт 106.6 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 5.1 дахь “Төсвийн байгууллага энэ журмын 3.1-т заасан үндэслэлээр дээд шатны төсвийн захирагчаас зөвшөөрөл авсны дагуу 4.1-т заасан агуулга бүхий зардлын бүлэг хооронд хийх зохицуулалтын саналаа харьяа төрийн санд хүргүүлнэ.” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Монгол Улсын Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр балах тухай аймгийн ИТХ-ын 2016 оны III/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэсэн аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/171 тоот захирамжаар Япон улсын Мория хоттой хамтын ажиллагаа тогтоох, туршлага судлах ажлаар 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд тус айлчлах бүрэлдэхүүнийг баталж, айлчлалд шаардагдах зардлыг тухайн байгууллагын төсвөөс гаргахыг төсвийн шууд захирагчид даалгаснаар 3.0 сая төгрөгийг түлш халаалтын зардлаас гаргасан байна.

Рашаант сумын ЗДТГ цалингийн зардалаас оны эцэст нэг удаа ЗДТГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/22 тоот тушаалаар ажилчдын үр дүнгийн гэрээг дүгнэж бүх ажилчдад жигдхэн 100.0 мянган төгрөг олгосон ба ЗДТГ-ын дарга үр дүнгийн гэрээний урамшуулал олгох тушаалаар өөртөө урамшуулал авсан зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Түлш халаалтын зардлаас 1186.4 мянган төгрөгөөр автомашины сэлбэг хэрэгсэл, усны тоолуур худалдан авахад 100.0, цэвэр бохир усны зардлаас 90.0 мянган төгрөг зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 5.1 дахь “Төсвийн байгууллага энэ журмын 3.1-т заасан үндэслэлээр дээд шатны төсвийн захирагчаас зөвшөөрөл авсны дагуу 4.1-т заасан агуулга бүхий зардлын бүлэг хооронд хийх зохицуулалтын саналаа харьяа төрийн санд хүргүүлнэ.” заалтыг зөрчсөн байна.

Мөн худалдан авсан 1509.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг хэрэгсэл, 190.0 мянган төгрөгийн усны тоолуурыг бараа материалын тайланд орлогодож аваагүй зөрчилд хөрөнгийн бүртгэл тайланд тусгах албан шаардлага өглөө.

Цаашид төсвийн зардлыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл, тодорхой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж батлагдсан хэмжээнд арвилан хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж байхад анхаарч ажиллаж, нягтлан бодогч няравын гаргасан бараа материалын тайланг үндэслэн хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнах, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийхгүй байх, холбогдох хууль журмыг баримталж ажиллах шаардлагатай байна.

Нэмэлт санхүүжилт:

Сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар 2017 онд ЗДТГ-ын үндсэн бус үйл ажиллагааны орлого, Гамшигаас хамгаалах сангаас цэцэг өвчинтэй тэмцэх зардал, Чацаргана төслөөс, Статистикийн хэлтэсээс мал тооллогын зардалд, Онцгой байдлын газраас гамшигийн томилолтын зардал, аймгийн ЗДТГ-аас өвс, тэжээлийн санхүүжилт, МУИС-аас ой хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд, ХХААГ-аас оготно устгалын зардал аж ахуйн нэгж, байгууллагын хандив дамжигдан орж зарцуулжээ.

Бугат сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар чацаргана төсөл, өвс тэжээл, аж ахуйн нэгжийн хандив, статистикийн мал тооллогын зардал, хог хаягдлын мөнгө зэргээр нийт 42155.1 мянган төгрөг орж 29463.8 мянган төгрөгийг зарцуулж 12691.4 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн нь тэжээл бэлдэх үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Бүрэгхангай нэмэлт санхүүжилтийн дансны 2017 оны 124127.5 мянган төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтыг аудит хийх хугацаанд ирүүлээгүй зөрчил илэрсэн нь Төрийн аудитын тухай хуулийн 21.1."Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй." гэсэн заалтыг зөрчиж байна.

Хангал сумын нэмэлт санхүүжилтийн дансанд "Чацаргана" хөтөлбөрөөс хашаа барих 10000.0, аймгийн Засаг даргын тамгын газраас чацарганы усалгааны тоног төхөөрөмж 3000.0, Статистик хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 305.0, машины дуудлага худалдаа 500.0, аймгийн нөөцөөс өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор 20000.0, Гамшгаас хамгаалах сангаас 90.0 мянган төгрөгний эх үүсвэр ирж Чацаргана төслийг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2017 оны А/99 тоот захирамжаар "Булган Аураг" ХХК-тай 10 га-д буюу 1260 м торон хашаа барих гэрээ байгуулан 10000,0 мянган төгрөг шууд гэрээ байгуулан олгосон, Чацаргана төсөлд хамрагдсан 21 иргэний 4 бүлд 3000,0 усалгааны тоног төхөөрөмж эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон хугацаа болоогүй, сумын Засаг даргын А/98 тоот захирамжаар урамшуулалд, унааны зардалд зарцуулсан, өвөлжилтийн бэлтгэл хангах Хялганат тосгонд 3800.0 олгосон тайланг тооцож аваагүй, "Эрдэнэт фүүдс" ХХК-иас 20 тн хивэг 1 кг нь 440 төгрөг нийт 8800.0, "Амуун далайн" ХХК-иас 10 тн багсармал тэжээл 1кг нь 500 төгрөг нийт 5000.0 төгрөг, зам даваа засах 471.2 төгрөг, сумын төвийн худгийн мотор авахад 286.0 төгрөг, шатахуунд 1642.8 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Тэжээлийн тооцоог хийхэд хивэг 1 шуудай 25 кг 800 шуудайг 11500 төгрөг тооцоход 9200.0 төгрөг үүнээс 762 шуудайг борлуулж 8763.0, багсармал тэжээл 1 шуудай 30 кг 333 шуудайг 15000 төгрөгөөр борлуулж 5000.0 төгрөг үүнээс 274 шуудайг борлуулж 4110.0 мянган төгрөг нийт 12873.0 мянган төгрөгийг сумын Байгаль хамгаалах санд төвлөрүүлж сумын нөөц хөрөнгийг бүрдүүлсэн байна. Одоогийн байдлаар 38 шуудай хивэгний үнэ 437.0, багсармал тэжээл 59 шуудай үнэ 885.0, нийт зээлээр олгосон үлдэгдэл 1322.0 мянган төгрөгийг хугацаанд нь төвлөрүүлэх шаардлагатай байна.

Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 23750.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэн бөгөөд томоохон зарцуулалтаас дурьдвал Хялганат тосгоны захирагчийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны А/44 тоот захирамжаар сум дунд дахь цагдаагийн тасагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжин хувь хүнээс Prius-10 маркын машингийн 5000.0 мянган төгрөгөөр худалдан авч өгөн одоо үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Рашаант сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар халаалтын орлого 4182.2, Хяналт шинжилгээ үнэлгээгээр 3-р байр эзэлсний шагнал 375.0, Гамшигаас хамгаалах сангаас цэцэг өвчинтэй тэмцэх зардалд 2000.0, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар автомашин худалдан авахад 40000.0, Чацаргана төслөөс 12000.0 мянган төгрөг, Зах зээл БУХ төслөөс 500.0, Статистикийн хэлтэсээс мал тооллогын зардалд 502.9, Онцгой байдлын газраас гамшигийн томилолтонд 32999.5, аймгийн ЗДТГ-аас өвсний санхүүжилт 20000.0, МУИС-аас ой хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд 633.4, ХХААГ-аас оготно устгалын зардалд 11520.0, усны худгийн ажилчинд урьдчилгааны 150.0 мянга нийт 124713.1 мянган төгрөгөөрийн санхүүжилт авч түлш халаалтын зардалд 3865.4, тээвэр шатахуунд 3833.5, томилолтын зардалд 31799.5, бусад төслийн зардалд 44897.9, автомашин худалдан авахад 40000.0 мянган төгрөг зарцуулж 466.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа чацаргана төсөл, өвс, тэжээл, гамшигаас хамгаалах сангаас малын эмчийн зардал, Статистикийн хэлтэсээс мал тооллогын зардал, сумын сургууль, цэцэрлэгээс махны үнэ зэргээр нийт 52094.7 мянган төгрөг орж, чацаргана төслийн 27999.9, өвсний фонд бэлтгэх 16000.0, шилмэл үүлдрийн бух худалдан авах 6720.0, жилийн эцсийн мал тооллогын зардал 477.4, цэцэг өвчний урамшуулал, галзуу өвчин туссан баавгай барих, устгахад зарцуулсан шатахуун, хайрцаг тээвэрлэх, ажилласан хүмүүсийн байр, хоол, бичиг хэргийн материал зэргийн нийт 897.4 мянган төгрөгийг дамжуулан зарцуулжээ.

Авлага, өглөг:

Сумдын ЗДТГ-ууд оны эхэнд 26339.7 мянган төгрөгийн авлагатай байснаас 10121.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж оны эцэст 36521.1 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

Тайлант оны эхэнд 92145.9 мянган төгрөгийн өглөгөөс 60062.3 мянган төгрөг барагдуулж оны эцэст 32083.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Оны эцсийн авлагыг сумдын ЗДТГ-аар задалж үзвэл Хутаг-Өндөр сумын ЗДТГ 17648.6 буюу нийт авлагын 48.3, Тэшиг 7868.9 буюу 21.5, Бүрэгхангай 3664.2 буюу 10.0, Хишиг-Өндөр 3160.7 буюу 8.7, Сайхан 2000.3 буюу, Баян-Агт 813.1 буюу 2.2, Баяннуур 577.6 буюу 1.6, Бугат 325.0 буюу 0.9, Хялганат 221.5 буюу 0.6, Булган 188.2 буюу 0.5, Хангал 52.8 мянган төгрөг буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Оны эцсийн өглөгийг сумдын ЗДТГ-аар задалж үзвэл Тэшиг сумын ЗДТГ 14640.0 буюу нийт өглөгийн 45.6, Хутаг-Өндөр 10405.9 буюу 32.4, Орхон 3017.9 буюу 9.4, Бүрэгхангай 1437.4 буюу 4.5, Сэлэнгэ 900.0 буюу 2.8, Бугат 674.4 буюу 2.1, Баяннуур 591.9 буюу 1.8, Сайхан 416.2 мянган төгрөг буюу 1.3 хувийг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө:

Сумдын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд 12 нэр төрлийн 195 автомашин бүртгэлтэй байгаагаас өртөгөө нөхөж элэгдэл нь дууссан 64 автомашин байна.

Сумдын автомашиныг хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэр	Нийт автомашины тоо														Бусад (чиргүүл)	Нийт
		Суудлын						Тусгай зориулалтын, тоноглогдсон									
		Жип	Дунд гарын жип	Жижиг суудлын машин	Автобус, микро автобус	УАЗ машин	Нийт/С	Трак- тор/авто ачигч, авто вышка	Газ, Зил-130	Портер пронтер маркийн	Замын, хүнд даацын машин	Мото- цикл, мопед	Тусгай тоног- лосон	Нийт /ТЗ			
1	Баян-Агт	1	1	0	1	1	4	4	0	0	0	2	2	8	0	12	
2	Баяннуур	2	0	0	0	3	5	2	0	0	0	0	0	2	1	8	
3	Бугат	3	0	0	0	0	3	6	1	0	0	7	0	14	0	17	
4	Булган	0	0	1	0	1	2	0	0	0	0	1	0	1	0	3	
5	Бүрэгхангай	1	1	0	1	0	3	3	0	3	0	2	0	8	4	15	
6	Гурванбулаг	1	1	0	0	1	3	0	0	1	1	0	1	3	1	7	
7	Дашинчилэн	0	0	0	0	3	3	3	0	0	0	3	5	11	0	14	
8	Могод	1	0	0	0	2	3	2	1	0	1	1	0	5	0	8	
9	Орхон	1	1	0	0	2	4	2	0	0	1	3	0	6	20	30	
10	Рашаант	1	0	1	0	1	3	3	0	0	0	2	3	8	0	11	
11	Сайхан	1	0	1	1	2	5	2	0	1	1	5	0	9	1	15	
12	Сэлэнгэ	2	0	0	0	2	4	3	1	0	1	0	2	7	0	11	
13	Тэшиг	2	1	0	0	2	5	3	0	0	2	3	0	8	0	13	
14	Хангал	1	0	1	1	2	5	2	0	0	0	2	0	4	0	9	
15	Хялганат	1	0	0	0	1	2	1	0	0	2	2	0	5	0	7	
16	Хишиг-Өндөр	2	0	0	0	0	2	1	0	0	0	0	3	4	3	9	
17	Хутаг-Өндөр	1	0	1	1	1	4	1	0	0	0	0	0	1	1	6	
		21	5	5	5	24	60	38	3	5	9	33	16	104	31	195	

Сэлэнгэ сумын ЗДТГ-т элэгдлээ бүрэн нөхсөн 10.0 сая төгрөгийн үнэтэй суудлын автомашиныг данснаас хасуулахаар аймгийн ИТХ-д санал хүргүүлснээр худалдаж мөнгийг нь төсвийн дансанд оруулсан боловч санал буцаагдсан, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй шалтгаанаар данснаас хасаагүй байгаа тул саналаа дахин явуулж данснаас хасах арга хэмжээ авахуулахаар албан шаардлага өглөө.

ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашигладаггүй барилга, автомашин

/сая.төг/

№	Сумдын нэр	ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй барилга, автомашины нэр	Ашиглалта нд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Ашиглагдахгүй байгаа шалтгаан /тайлбар бичнүү/
Барилга, байгууламж								
1	Баяннуур	80-н байр	1981.01.01	63	185.5	110.8	74.8	Эвдэрсэн
2	Баяннуур	Халуун усны байр	1983.04.20	63	17.0	9.5	7.5	Эвдэрсэн
3	Баяннуур	Замын цагдаагийн пост	2006.10.01	63	0.7	0.1	0.6	Эвдэрсэн
4	Дашинчилэн	Ногооны зоорь /Нийтийн эзэмшлийн хөрөнгө/	2008.12.31	20	5.0	2.2	2.8	Банз нь илжирч, даацийн хана нурж, газар нь цоморсон. Цаашид ашиглах боломжгүй.
5	Могод	Конторын барилга	1971 он	36	155801.6	119925.1	35876.5	Дээрээс нь бороо гойждог, ашигдах ямар ч боломжгүй болсон учир одоо ашиглахгүй байгаа

6	Могод	Зочид буудлын барилга	1971 он	36	73032.0	56,214.9	16817.1	Дээврээс нь бороо гойждог, ашигдах ямар ч боломжгүй болсон учир одоо ашиглахгүй байгаа
7	Могод	Музейн барилга	1971 он	36	34,994.5	26,936.3	8,058.2	Дээврээс нь бороо гойждог, ашигдах ямар ч боломжгүй болсон учир одоо ашиглахгүй байгаа
8	Сайхан	Музейн	1978.11.03	15	6.9	6.9	0.0	Музейн барилга шинээр баригдах хүртэл ашиглагдаж байгаад одоо ашиглагдахаа больсон
9	Хишиг-Өндөр	Склад	1985.01.01	10	3.6	3.6	0.0	Ашиглалт муу, засварт хөрөнгө шаардлагатай
10	Хишиг-Өндөр	Зоорь	1985.01.02	10	5.4	5.4	0.0	Хучилт цөмөрсөн, засварт хөрөнгө шаардлагатай
11	Хишиг-Өндөр	Хөргүүрт зоорь	2010.12.31	13	31.9	18.4	13.5	Газрын маргаантай
Автомашин, тээврийн хэрэгсэл								
1	Баяннуур	Бага оврын трактор	2009.01.20	6	1.9	1.9	0.0	Эвдэрсэн
2	Баяннуур	трактор	2012.12.31		19.1	0.0	19.1	Эвдэрсэн
3	Гурванбулаг	авто машин Фермер МЭҮТасаг	2012 он	4	20.0	20.0	0.0	Гал түймэрийн улмаас эвдэрсэн
4	Гурванбулаг	Авто машин /хогны/	2014 он	6	28.0	16.3	11.7	Эвдэрсэн
5	Гурванбулаг	Ухдаг түрдэг трактор	2014 он	6	50.0	29.2	20.8	Эвдэрсэн
6	Дашинчилэн	Усны машин БУА 0219	2011.12.31	6	26.7	26.7	0.0	Эвдэрсэн
7	Дашинчилэн	Мотоцикль	2013.12.31	6	1.3	0.4	0.9	Эвдэрсэн цаашид сэлбэх боломжгүй.
8	Дашинчилэн	Мотоцикль	2013.12.31	6	1.8	0.6	1.2	Эвдэрсэн цаашид сэлбэх боломжгүй.
9	Могод	Ланд-80 автомашин	2010 он	6	12,200.0	12,200.0		Балансаас балансад шилжүүлэх санал хүргүүлсэн
10	Орхон	Бүргэд мотоцикль	2008.04.30	6	6.2	6.2	0.0	Элэгдэл дуусч, эвдэрч хэмхэрсэн шаардлага хангахгүй болсон
11	Орхон	чиргүүл 69-ны	2007.12.01	6	0.5	0.5	0.0	Элэгдэл дуусч, эвдэрч хэмхэрсэн шаардлага хангахгүй болсон
12	Орхон	Бага оврын трактор	2008.10.11	6	1.0	1.0	0.0	Элэгдэл дуусч, эвдэрч хэмхэрсэн шаардлага хангахгүй болсон
13	Орхон	Хадуур	2008.01.11	7	0.4	0.4	0.0	Элэгдэл дуусч, эвдэрч хэмхэрсэн шаардлага хангахгүй болсон
14	Орхон	Тармуур	2008.10.11	7	0.3	0.3	0.0	Элэгдэл дуусч, эвдэрч хэмхэрсэн шаардлага хангахгүй болсон
15	Орхон	Чиргүүл/тракт орны	2008.10.11	6	0.2	0.2	0.0	Элэгдэл дуусч, эвдэрч хэмхэрсэн шаардлага хангахгүй болсон

16	Сайхан	Уаз-31512	2011.07.20	6	19.4	19.4	0.0	Явах эд анги муудсан хөдлөх ямарч боломжгүй засварлаж байж хөдөлнө
17	Сайхан	Пробок машин	2014.04.01	6	12.0	8.3	3.7	Явах эд анги муудсан хөдлөх ямарч боломжгүй засварлаж байж хөдөлнө
18	Сайхан	микро автобус	2009.12.26	6	6.5	6.5	0.0	Анх шуудан зөөх зориулалтаар УИХ гишүүн Ц.Цэнгэл гэрээгээр өгч байсан тухайн үед уг машины гэрчилгээг ЗДТГ нэр дээр шилжүүлэн аваагүй одоо актлах санал оруулахаар нэр зөрүү байна гээд актлах боломжгүй байна.
19	Сайхан	хүлэг мотоцикл	2008.12.15	6	2.5	2.5	0.0	Устаж үгүй болсон актлах гэхээр зураг бичиг баримт нэхэгддэг
20	Сайхан	хонда мотоцикл	2009.12.31	6	2.0	2.0	0.0	Устаж үгүй болсон актлах гэхээр зураг бичиг баримт нэхэгддэг
21	Сайхан	Бага оврын троктер	2008.12.15	6	4.0	4.0	0.0	Гэрээгээр эзэмшиж байгаад одоо гэрээний хугацаа дуусаад шилжүүлэх гэхээр баримтын бүрдэл дутуу гэдэг
22	Сайхан	Портер	2008.12.15	6	3.0	3.0	0.0	Гэрээгээр эзэмшиж ашиглаж байгаад одоо гэрээний хугацаа дууссан.
23	Хишиг-Өндөр	Бага оврын трактор	2009.06.01	10	4.0	3.4	0.6	эвдэрсэн, засварт хөрөнгө шаардлагатай
Нийт					276495.0	215586.1	60908.9	

Сайхан суманд хандиваар ирсэн гэрээний хугацаа дуусахад ажлуулж байсан иргэнд шилжүүлэх гэрээтэй, 4.0 сая төгрөгийн дансны үнэ бүхий элэгдэл дууссан бага оврын трактор, 3.0 сая төгрөгийн дансны үнэтэй элэгдэл дууссан портерыг гэрээний хугацаа дуусаад шилжүүлэх гэхэд баримтын бүрдэл дутуу гээд шилжүүлдэггүй, мөн анх шуудан зөөх зориулалтаар УИХ гишүүн Ц.Цэнгэл гэрээгээр өгч байсан тухайн үед уг машины гэрчилгээг ЗДТГ нэр дээр шилжүүлэн аваагүй одоо актлах санал оруулахаар нэр зөрүүтэй гээд актладаггүй байна.

Сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй ашигладаггүй, эвдэрсэн, элэгдлээ нөхсөн барилга байгууламж, авто тээврийн хэрэгслийг акталж данс бүртгэлийг цэгцлэх шаардлагатай байна.

2.2. Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа ЗГ-ын тогтоол, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг сумдууд ИТХ-аараа 10000.0-24000.0 мянган төгрөгөөр батлуулан зарцуулсан байна.

Засаг даргын нөөцийн хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэл:

/мян.төг/						
№	Сумдын нэр	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв тодотголын зөрүү	Тодотгосон төсөв гүйцэтгэлийн зөрүү
1	Баян-Агт	10000.0	10500.0	10500.0	500.0	0.0
2	Баяннуур	10000.0	10000.0	10000.0	0.0	0.0
3	Бугат	10000.0	10000.0	10000.0	0.0	0.0
4	Булган	20000.0	24000.0	23850.0	4000.0	150.0
5	Бүрэгхангай	10000.0	16000.0	14495.9	6000.0	1504.1
6	Гурванбулаг	10000.0	23000.0	22998.4	13000.0	1.6
7	Дашинчилэн	10000.0	12800.0	12797.3	2800.0	2.7
8	Могод	10000.0	19000.0	18999.4	9000.0	0.6
9	Орхон	10000.0	11500.0	11500.0	1500.0	0.0
10	Рашаант	10000.0	17000.0	17000.0	7000.0	0.0
11	Сайхан	10000.0	10000.0	10000.0	0.0	0.0
12	Сэлэнгэ	10000.0	19000.0	19000.0	9000.0	0.0
13	Тэшиг	10000.0	10000.0	9999.5	0.0	0.5
14	Хангал	10000.0	10000.0	9991.2	0.0	8.8
15	Хишиг-Өндөр	10000.0	10000.0	9982.5	0.0	17.5
16	Хутаг-Өндөр	10000.0	10796.7	10794.5	796.7	2.2
17	Хялганат	10000.0	10000.0	10000.0	0.0	0.0
	Нийт дүн	150000.0	233596.7	233412.8	53596.7	1688.0

Сумдын Засаг даргын нөөцийн зарцуулалтыг авч үзвэл.

Рашаант сумын ЗДТГ нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1 дэхь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал: Манжуур хотын аялалд 1,500.0, Улаан-Үд хотын аялалд 1,700.0, Засаг даргын тамгын газрын автомашины сэлбэгт 500.0, ажилтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхэд зориулж 500.0, сумын шинэ жилийн баярын арга хэмжээнд зориулж сумын Засаг даргын А/165 дугаартай захирамжаар 1411.4 мянган төгрөгийн төсөв баталсан боловч 2035.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж журам зөрчсөн байна.

Бүрэгхангай сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 7 иргэнд 1258.5 мянган төгрөгийг дэмжлэг туслалцаа буюу буцалтгүй тусламж, хүндэтгэлд, 10 иргэнд 1800.0 мянган төгрөгийг эмчилгээний зардалд, бусад зардалд 2467.5, шатахууны зардалд 5881.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсанаас анхан шатны баримтын бүрдэлт дутуу шатахуун зарцуулалтын 1581.8, тэмцээн уралдаан болон шинэ жилийн арга хэмжээнд оролцсон иргэдийн шагналаас ХХОАТ-ыг суутган шилжүүлээгүй 134.0, анхан шатны

баримтын бүрдэлгүй тушаал шийдвэргүй 769.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ХХОАТ-ын 142.0 мянган төгрөгийг сумын орлогын дансанд төвлөрүүлээгүй зөрчлийг аудитын явцад барагдуулж ажиллалаа.

Сумдын Засаг даргын нөөцийг зарцуулах сумын Засаг даргын захирамж нь Сангийн сайдын 2012 оны “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэсэн заалтыг үндэслэсэн нь захирамжийн эрх зүйн үндэслэл харьцангуй учир дутагдалтайг илэрхийлж буйд цаашид анхаарах шаардлагатай байна.

Сумдын Засаг даргын нөөцийг журмын 3.1 дэх “Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” гэж заасны дагуу зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр Засаг даргын захирамжаар зарцуулжээ. Үүнээс үзэхэд журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.3. ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг боловсруулж тайлант оны ололт болон сул талыг үнэлж дүгнэсэн хэдий ч батлагдсан төлөвлөгөөний дагуу дээрх үйл ажиллагаа бүтээгдэхүүн бүрээр тооцон гаргаагүйгээс нийт хэдэн хувийн биелэлттэйг илэрхийлэх боломжгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжэлгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсээс сумдын ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаанд дараах үнэлгээг өгсөн байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэр	Ерөнхий үнэлгээ оноогоор	Эзэлсэн байр
1	Баян-Агт	3.53	14
2	Баяннуур	4.00	10
3	Бугат	3.41	16
4	Булган	4.38	3
5	Бүрэгхангай	3.59	12
6	Гурванбулаг	3.40	17
7	Дашинчилэн	4.05	6
8	Могод	4.03	8
9	Орхон	3.51	15
10	Рашаант	3.54	13
11	Сайхан	4.03	7
12	Сэлэнгэ	4.39	2

13	Тэшиг	4.17	5
14	Хангал	4.29	4
15	Хишиг-Өндөр	3.94	11
16	Хутаг-Өндөр	4.41	1
17	Хялганат	4.02	9

Сумдын ЗДТГ-уудын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтээс дурдвал:

Бугат сумын ЗДТГ нь 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 36 ажил хийхээр төлөвлөж, ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг боловсруулж тайлант оны ололт болон сул талыг үнэлж дүгнэсэн хэдий ч батлагдсан төлөвлөгөөний дагуу хийсэн үйл ажиллагааг бүтээгдэхүүн бүрээр тооцон гаргаагүйгээс биелэлтийг дүгнэх боломжгүй байна.

Рашаант сумын ЗДТГ нь 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 7 бүлэгтэй 45 ажил хийхээр төлөвлөж, ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг боловсруулж тайлант оны ололт болон сул талыг үнэлж дүгнэсэн хэдий ч батлагдсан төлөвлөгөөний дагуу дээрх үйл ажиллагаа бүтээгдэхүүн бүрээр тооцон гаргаагүйгээс биелэлтийг дүгнэх боломжгүй байна.

Бүрэгхангай сумын ЗДТГ нь 2017 онд зорилтот 18 бүлгийн нийт 119 асуудлаар үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн боловч үйл ажиллагааны биелэлтийг тооцож ажиллаагүй зөрчил илэрч аудитын явцад биелэлтийг тооцуулан гаргахад 17 ажил огт хийгдээгүй, 102 ажил хийгдэж 2017 оны үйл ажиллагааны биелэлт 85 хувьтай гарч байна.

Хялганат тосгоны Захирагчийн ажлын алба 2017 онд гурван зорилтын хүрээнд нийт 17 үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, Захирагчийн ажлын албаны 2017 оны үйл ажиллагаа, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг боловсруулж тайлант оны ололт болон сул талыг үнэлж дүгнэсэн хэдий ч батлагдсан төлөвлөгөөний дагуу дээрх үйл ажиллагаа бүтээгдэхүүн бүрээр тооцон гаргаагүйгээс биелэлтийг хувиар илэрхийлэх боломжгүй байна.

Хангал сум нь 16 бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж биелэлтийг бүтээгдэхүүн тус бүрт дэд төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Тухайлбал:

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөө гарган сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчидтай 4 жилийн төлөвлөгөөний биелэлтийг жил бүр албан хаагчдад хавтас нээлгэн хэрэгжилтийг тооцож ажиллажээ.

Аймгийн түүхт 80 жилийн ой угтаж бүтээлч ажлын дэд төлөвлөгөө боловсруулан иргэд, аж ахуйн байгууллагаас хандив цуглуулах, сум байгууллагын тохижилт, өнгө үзэмж, гадна дотно орчныг сайжруулах ажлуудыг хийсэн байна.

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор дэд төлөвлөгөө боловсруулан ажиллаж төрийн албан хаагчдыг зээл тусламжинд хамруулах, Засаг даргын санаачилгаар 3 жилийн хугацаатай 8 албан хаагчдыг малжуулах төсөлд хамруулах, шинэ ирсэн боловсон хүчнийг дэмжиж МЭҮТ-ийн мэргэжилтэн, ня-бо,

сургуулийн захирал нарыг орон байраар хангах, албан хаагчдыг өмчлөлийн болон эзэмшлийн газартай болгох, мэргэжил дээшлүүлэх зэрэг тодорхой ажил хийсэн байна.

Аймаг, сумдын Засаг даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг хангаж ажиллах дэд хөтөлбөрийг боловсруулж төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг орон нутагт чиглүүлж Дэлхий Зөн ОУБ-аас тусламж авах, тэжээлийг үнэгүй авч Байгаль хамгаалах сангийн нөөц бүрдүүлсэн, төсвийг үр ашигтай зарцуулах, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, иргэдийн аюулгүй амьдрах орчныг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зэрэг 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг тооцож тайлагнасан байна. Үр дүн нь Хангал сум 2017 оны ажлаараа аймагт 4 дүгээр байрт шалгарчээ.

Дээрхээс үзэхэд сумдын ЗДТГ-ууд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж байгаа хэдий ч, батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа бүтээгдэхүүн бүрээр хийсэн ажилыг тооцож биелэлтийг дүгнээгүй байна.

Аудитаар нийт 42516.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын явцад 134.0 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулж, 3293.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулан, 2206.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 36883.3 мянган төгрөгийн албан шаардлага бичиж ажиллалаа.

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

16 сум, 1 тосгоны ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа,
төсвийн гүйцэтгэл

**Дүгнэлт,
зөвлөмж**

Сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй ашигладаггүй, эвдэрсэн, элэгдлээ нөхсөн барилга байгууламж, авто тээврийн хэрэгслийг акталж данс бүртгэлийг цэгцлэх шаардлагатай байна.

Аудитаар 16 сум, 1 тосгоны ЗДТГ-аас түүвэрлэн Бугат, Бүрэгхангай, Сэлэнгэ, Рашаант, Хангал сум, Хялганат тосгоны 6 ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд аудит хийгдсэн ба аудитын дүнгээс:

- Орлогыг дутуу төлөвлөдөг, тооцоо судалгаан дээр үндэслэн орон нутгийн онцлогт тохируулан орлогыг төлөвлөөгүйгээс орон нутгийн зарим нэр төрлийн орлого тасарч, зарим нэр төрлийн орлогын биелэлт өндөр, орон нутгийн татварын орлогыг биелүүлж Татварын тухай хуулийн 29.1.10 “албан татвар, төлбөр, хураамж, алданги, торгуулийг хуульд заасан хугацаанд хурааж төсөвт оруулах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн төлөвлөж батлуулан зарцуулаагүй,
- Орлого биелэхээр тодотгол хийж нөөц хөрөнгөнд зарцуулдаг, жил бүр тасарсан орлогоос хог хаягдлын үйлчилгээний хураамж байнга тасардаг, хариуцах албан тушаалтангүй, тасарсан орлогын шалтгаан нөхцөлийг тогтоож, ажлын хариуцлага тооцдоггүй,
- Батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд болон зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, нягтлан бодогч няравын тайланд үндэслэн санхүүгийн тайлангаа тайлагнаагүй, ажилтнуудын цалин нэмэгдлийг тогтоосон тушаалд ур чадварыг нэмэгдлийг шууд тогтоож өгсөн, худалдсан үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй, худалдаж авсан эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа ЗГ-ын тогтоол, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг боловсруулж тайлант оны ололт болон сул талыг үнэлж дүгнэсэн хэдий ч

батлагдсан төлөвлөгөөний дагуу дээрх үйл ажиллагаа бүтээгдэхүүн бүрээр тооцож гаргаагүй.

- Сумдын ЗДТГ, сумдын удирдлага, холбогдох ажил хариуцсан албан тушаалтантан, мэргэжилтэнүүд орлогыг бүрэн төлөвлөж, биелүүлэх, ашиглалтгүй болсон барилга, автомашин, мотоцикль зэргийг тухай бүр эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авч данснаас хасаагүйгээс үнэ цэнээ илүү алдсан, тоногдож муудсан зэрэг зөрчил, дутагдал илэрсэн тул сумдын ЗДТГ-ын хөрөнгө зарцуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих дотоод хяналтыг сайжруулж бусад төрлийн байгууллагуудад үлгэр жишээ, манлайлал болон ажиллаж, үйл ажиллагаандаа хууль, журмыг чанд мөрдөж ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Зөвлөмж

Булган аймгийн Засаг дарга З.Батзориг танаа:

1. Орон нутгийн орлогын тасарсан шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлон ажлын хариулага тооцох.
2. Сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн харилцан адилгүй зарцуулалт, мөн журмыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаад хяналт тавьж ажиллах.
3. Сумдын төсвийн тодотголыг орлого нэмэгдсэн хэмжээгээр хийж, зарцуулдаг байдалд хяналт тавьж төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулахад анхаарч ажиллах.
4. Сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй ашигладаггүй, эвдэрсэн, элэгдлээ нөхсөн барилга байгууламж, авто тээврийн хэрэгслийг акталж данс бүртгэлийг цэгцлэхийг зөвлөж байна.

Мэдэгдэл:

Аудитаар илэрсэн зөрчилийг арилгаж дахин давтан гаргахгүй байхад анхаарч, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар сумын удирдлагуудад албан ёсоор мэдэгдэж хүрсэн үр дүн, зохион байгуулсан ажлынхаа талаар албан ёсоор 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор тус газарт ирүүлэхийг мэдэгдье.

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Д.ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:
АУДИТОР

Д.ДААРИЙМАА

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ГОНЧИГ

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
Ж.ШҮРЭНБАГАНА

НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ЭНХБАЯР